Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Ажил мэргэжлийн чиг баримжаа, оюутны хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн, Цэдэндамбаа Намжилмаа

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОЮУТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ | | | | | | | |
| 1 | “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох”, "Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол улсын их сургууль, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнтэй хамтран “АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО, ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙН АСУУДАЛД ЗӨВЛӨЛДӨХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ”-ийг 2025 оны IY сард зохион байгуулж, "Боловсролын салбар дахь ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээний чанар, хүртээмж" илтгэлийг хэлэлцүүлсэн 2. Дэвжих | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ТББ, нийслэлийн Боловсролын газартай хамтран 2025 оны Ү сард “EDU Expo-2025” үзэсгэлэнг 15 дах жилдээ зохион байгуулсан. 3. ЦЕГ, ДХИС-тай хамтран Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах “Өнөөдөр сонго, маргааш бүтээцгээе” нээлттэй хаалганы өдөрлөгийг орон нутагт 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, нийслэлд 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгууллаа. 4. Боловсролын сайдын 2024 оны А/123 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсролын ерөнхий газар, “Юнайтед Карьер хөгжлийн төв” НҮТББ хамтран нийслэлийн 7 дүүргийн сонгогдсон 20 ерөнхий боловсролын сургуульд “Ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хичээл сонголтод дэмжлэг үзүүлэх” төсөл хэрэгжүүлсэн 5. Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар анги, мэргэжлийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор БЕГ-ын даргын 2025 оны А/26 дугаар тушаалаар батлагдсан "Мэргэжлээ зөв сонгоё" цахим аяныг зохион байгуулсан. 6. Оюу толгой ХХК-тай хамтран Улаанбаатар хотод зохион байгуулсан "Боловсролын өдөрлөг"-т нийслэлийн 9 дүүрэг, Төв аймгийн 4 сумын 2000 гаруй сурагч болон дээд сургуулийн 1,000 гаруй оюутан оролцон, "Дотоодын тэтгэлэгт хөтөлбөр", "Залуусын хөгжлийн хөтөлбөр"-т шалгарсан 40 оюутан батламж гардан авлаа 7. Тэтгэлэг апп, Дэвжих ТББ, МХО-той хамтран "Ажил орлоготой оюутан" үйл ажиллагааны удирдамж боловсруулсан 8. БЕГ-ын пэйжээр 1 аймаг, 2 дүүрэг, 6 сургуулийн Сайн туршлагыг түгээсэн<br>Хавсралт: 8 файл | | |
| 2 | Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, | - Сургалт үйл ажиллагааны | Сургалт - 1, хамрагдсан | Үйл ажиллагаа - 1 Хамрагдсан | Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, | 1-р сар, 2-р сар, 3-р | Өөрийн үнэлгээ: |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүүргийн боловсролын хэлтсийн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Насан туршийн суралцахуйн төвийн “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн танхим”-ыг хариуцан ажилладаг багш нарыг суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох арга зүйд сургахад чиглэсэн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах | тоо - Хамрагдсан хүний тоо | хүний тоо - 62 | хүний тоо - 70 | дүүргийн боловсролын хэлтсийн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Насан туршийн суралцахуйн төвийн “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээллийн танхим”-ыг хариуцан ажилладаг багш нарыг суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох арга зүйд сургах зорилгоор: 1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголтод дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны 2024-2025 оны Зөвлөмж, календарьчилсан төлөвлөгөөг 21 аймаг, 9 дүүрэгт хүргүүлэн, АМЧБО салбар зөвлөлийн 62 албан хаагчтай сар тутам цахим уулзалт, 2 удаа цахим сургалт хийж, мэдээллээр ханган чиглүүлэн ажиллаж байна 2. Өвөрхангай аймгийн Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох салбар зөвлөлөөс Боловсролын ерөнхий газар, “Хөгжлийн Долоон Арга” төрийн бус байгууллагатай хамтран 2025 оны 02 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг зохион байгуулах арга зүй” | сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сургалтыг аймгийн засаг даргын дэмжлэгтэйгээр зохион байгууллаа. Сургалтад ерөнхий боловсролын 32 сургууль, политехник коллежийн сургалтын менежер, нийгмийн ажилтан, насан туршийн арга зүйч багш, нийт 70 хүн хамрагдсан. 3. “Сургуульд суурилсан АМЧБО үйл ажиллагаа” цахим агуулгыг боловсруулан Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын цахим талбараар 4610 багш, удирдах ажилтанд хүргэж ажиллав.<br>Хавсралт: 3 файл | | |
| 3 | ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчид, МБСБ-ийн суралцагчдад “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох” чиглэлээр судалгаа, мэдээллийн сан бүрдүүлэн ажиллах. | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Аймаг, дүүргийн түвшинд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагааны мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор 3 бүлэг 11 төрлийн үйл ажиллагааны асуулга бүхий судалгааг авч нэгтгэн, 2025 оны хэрэгжилтэд тайлагнав. Үүнд: НЭГ. Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд 21 аймаг, 5 дүүргийн мэдээллээр: 1. Ерөнхий боловсролын 702 сургуулийн 8-12 дугаар ангийн 128,214, тусгай | 6-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгцээт 793 буюу нийт 129,007 сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан бөгөөд үүний 78.994 сурагч буюу 53.52%-ийг эмэгтэй сурагч эзэлж байна 2. Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан ажил мэргэжил сонгох чиглэлийн зөвлөх үйл ажиллагаанд 32,167 хүн хамрагдсан 3. Мэргэжил сонголтод туслах зорилгоор 649 контент боловсруулан түгээгээд байна ХОЁР: Аймаг, дүүргийн түвшинд: 1. Ерөнхий боловсролын сургуулийн 1035 багш, удирдах ажилтанд "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах арга зүйн сургалт зохион байгуулж, 422 зөвлөмж боловсруулан хүргүүлсэн. 2. Орон нутгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар болон иргэдтэй хамтран ерөнхий боловсролын 462 сургуулийн 8-12 дугаар ангийн 32.079 сурагч, 13.701 эцэг эхэд “Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал, ажлын байрны захиалга, ажлын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байранд тавигдах шаардлага, ажил мэргэжлийн талаарх танилцуулга” сургалт, сурталчилгаа, зөвлөх үйлчилгээг үзүүлсэн байна 3. НТСТ-ийн дэргэдэх мэдээллийн танхимаар дамжуулан ерөнхий боловсролын 483 сургуулийн 34,971 сурагч, тусгай хэрэгцээт 232 сурагч, мэргэжлийн боловсролын 26 сургуулийн 3,260 суралцагч буюу нийт 38,463 суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт нөлөөллийн ажил зохион байгуулж, 649 контент боловсруулан түгээгээд байна. 4. Сэтгэл зүйн засал, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлж, зөв амьдрах дадал хэвшил хувь хүний хөгжлийг дэмжих чиглэлээр 238 сургуулийн 18.185 сурагч, 141 сургуулийн 4.169 эцэг эх асран хамгаалагчдад сургалт нөлөөллийн ажил зохион байгуулсан байна<br>Хавсралт: 1 файл | | |
| 4 | Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр судалгаа, мэдээллийн сан | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 6-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрдүүлэн ажиллах | | | | чиглэлээр хийж хэрэгжүүлж байгаа ажлын чиглэлээр 3 бүлэг, 12 асуулга бүхий судалгааг авч нэгтгэлээ. Үүнд: • 1. Энэ 2024 онд 11 сургуулийн 3637 оюутан хөдөлмөр эрхэлж байгаагаас 2296 оюутан цагийн ажил хийж байгаагийн 73,5% буюу 1688 нь эмэгтэй оюутан байна. 2. Мөн өөрийн суралцаж буй мэргэжлээрээ 1675 оюутан ажил эрхэлж байгаагийн 38,4% буюу 644 нь эмэгтэй оюутан байна 3. МУБИС, Отгонтэнгэр их сургуулийн оюутнууд ажлын байр бий болгох 37 төсөл бичсэнээс 5 төслийг нь сургуулиас 17,322 мянган төгрөгөөр санхүүжүүлэн, 122 оюутанд ажлын байр бий болгосон байна.<br>Хавсралт: 1 файл | | |
| 1.2. АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ОЮУТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ | | | | | | | |
| 5 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ, үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлэх | Хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллагын тоо Зохион байгуулсан үйл ажиллагааны | 100 | Хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллагын тоо - 1 Зохион байгуулсан үйл ажиллагааны | 1, ДЭВЖИХ ТББ: - Суралцагчдад хөдөлмөрийн зах зээл, ажил мэргэжлийн чиг хандлага, дотоод гадаадын тэтгэлэгт хөтөлбөр, төрийн болон төрийн бус өмчийн их, дээд, мэргэжлийн боловсролын сургалтын | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тоо | | тоо - 1 | байгууллагуудын танилцуулга хийх, сурталчлах, мэдээ, мэдээлэл түгээх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд “EDU Expo-2025” үзэсгэлэнг 15 дах жилдээ зохион байгуулж, алслагдсан сургуулийн суралцагчдад автобусаар үнэ төлбөргүй үйлчилсэн. - Үзэсгэлэнд 30,000 сурагч, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл, Монголын Их Дээд Сургуулиудын Консорциум, Хувийн Их Дээд Сургуулиудын Холбоо, дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагууд оролцон мэдээлэл сурталчилгаа хийсэн 2. ЦЕГ, ДХИС: - Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах “Өнөөдөр сонго, маргааш бүтээцгээе” нээлттэй хаалганы өдөрлөгийг орон нутагт 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр, нийслэлд 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгууллаа. - Нээлттэй хаалганы өдөрлөгт 80,000 орчим хүн оролцож, мэдээлэл авч, | сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчлүүлсэн бөгөөд, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын төгсөх ангийн 5,000 орчим сурагч оролцон Дотоод хэргийн их сургуулийн үйл ажиллагаа, элсэн суралцах мэргэжлийн чиглэл, оюутан элсүүлэх журамтай танилцан, зөвлөгөө зөвлөмж авсан. 3. Оюу толгой ХХК: Нийслэлд зохион байгуулсан "Боловсролын өдөрлөг"-т нийслэлийн 9 дүүрэг, Төв аймгийн 4 сумын 2000 гаруй сурагч болон дээд сургуулийн 1,000 гаруй оюутан оролцон, Оюу толгой ХХК-ий "Дотоодын тэтгэлэгт хөтөлбөр", "Залуусын хөгжлийн хөтөлбөр"-т шалгарсан 40 оюутан батламжаа гардан авлаа. 4. SDC PRO ТББ: “Хүний нөөцийн шилжилтийн стратегийн чиглэлүүд, хурдасгуур хөтөлбөрүүдийн санал" сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг 2025 оны Ү сард зохион байгуулж нийслэлийн 7 дүүргийн ЕБС-ийн ахлах ангийн 100 суралцагч оролцон , дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн чиг хандлага, нийслэл болон улсын хэмжээнд хэрэгжиж буй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мега болон дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүд, ирээдүйн ажлын байрны ур чадвартай танилцлаа Хавсралт: 5 файл | | |
| 6 | Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг бэхжүүлэх | Хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллагын тоо Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 100 | Хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллагын тоо - 1 Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо - 1 | 1. Оюу толгой ХХК-тай хамтран 2025 оны III сард зохион байгуулсан ""оюу толгойн тэтгэлэг" арга хэмжээнд их, дээд сургуулийн 1,000 гаруй оюутан оролцон, Оюу толгой ХХК-ий "Дотоодын тэтгэлэгт хөтөлбөр", "Залуусын хөгжлийн хөтөлбөр"-т шалгарсан 40 оюутан батламжаа гардан авлаа. 2. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Тэтгэлэг апп, Дэвжих ТББ, МХО-той хамтран "Ажил орлоготой оюутан" үйл ажиллагаа, "Цагийн ажилтай оюутан", "Цалинтай дадлага", "Оюутны зуны ажил" арга хэмжээний хөтөлбөр, удирдамжийн төсөл боловсруулан, 2025 оны 9 дүгээр сараас эхлэн зохион байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | Өөрийн үнэлгээ: 90% |
| 7 | "Мэргэжлээ зөв сонгоё" аян зохион байгуулах | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар анги, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын | 1-р сар, 2-р сар, 3-р сар | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | суралцагчдад ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголттой холбоотой зөвлөмж, мэдээллийг цахимаар хүргэн, мэргэжлээ зөв сонгоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор Грэйт Айкт ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, БЕГ-ын даргын 2025 оны А/26 дугаар тушаалаар "Мэргэжлээ зөв сонгоё" аяныг зохион байгууллаа. Аяны хүрээнд: - Мэргэжил сонголтын тухай ерөнхий ойлголт, Мэргэжил эзэмших боломж, Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал гэсэн гурван агуулгын хүрээнд 18 постер, 6 рийл, 6 бичлэг бэлтгэн БЕГ-ын цахим хуудсаар түгээж, 18 нийтлэл бэлтгэн вэб сайтад байршуулсан - Давхардсан тоогоор 780,000 орчим хэрэглэгч үзэж сонирхон, 4500 гаруй хэрэглэгчийн хандалт авч, 5000 гаруй хэрэглэгч цааш түгээн дэлгэрүүлсэн байна. - Энэ аяны хүрээнд БЕГ-ын пэйжээр дамжуулан Боловсролын сэтгэл зүйч, Тусгай хэрэгцээт боловсролын багш, Боловсролын нийгмийн ажилтан, Хоол зүйч, Эмч, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Сургуулийн өмнөх боловсролын багш мэргэжлүүдийг цувралаар танилцуулан сурталчиллаа - Аймаг, дүүргийн АМЧБО Салбар зөвлөлүүд орон нутагтаа "Мэргэжлээ зөв сонгоё аян"-ыг өргөжүүлэн зохион байгуулсан бөгөөд ерөнхий боловсролын 702, мэргэжлийн боловсролын 33 сургуулийн YIII-XII ангийн 123,653 суралцагч, 36,161 эцэг эх, асран хамгаалагч, иргэдийг хамруулсан байна - Мөн Орхон аймаг, Хан-Уул, Баянзүрх дүүрэг, нийслэлийн 122, 92, 102, 148, 155, 157 дугаар сургуулиудын Сайн туршлагыг Боловсролын ерөнхий газрын пэйжээр түгээн дэлгэрүүлсэн<br>Хавсралт: 5 файл | | |
| 8 | Ерөнхий боловсролын 9 дүгээр ангийн суралцагчдад "Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хичээл сонголтод дэмжлэг үзүүлэх" үйл ажиллагааг нийслэлийн 7 дүүргийн сонгогдсон 20 сургуульд зохион байгуулах, ажлын үр дүнг үндэсний түвшинд түгээн | Хэрэгжилтийн хувь | - | 100 | Боловсролын сайдын 2024 оны А/123 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсролын ерөнхий газар, “Юнайтед Карьер хөгжлийн төв” НҮТББ хамтран нийслэлийн 7 дүүргийн сонгогдсон 20 ерөнхий боловсролын сургуульд дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: 1. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дэлгэрүүлэх | | | | БЕГ, ЮКХТ хамтран 2025.01.29 – 2025.02.03-ны өдрүүдэд төслийн удирдамж, төлөвлөгөөг танилцуулж, сургалтын хуваарь товлон, хамтран ажиллах гэрээ байгуулсан. 2. “Мэргэжлээ ухаалгаар сонгоё” сэдвээр мэргэжил сонгоход юуг анхаарах, мэргэжил сонголтын олон улсын аргачлал, эрэлттэй болон устаж үгүй болох ажил мэргэжлүүдийн талаарх ойлголт, төслийн хүрээнд хамрагдах VOCATION-Ажил мэргэжлийн сонирхол карьерын чиг баримжааг тодорхойлох үнэлгээний ач холбогдол, хэрхэн үнэлгээнд хамрагдах талаар сургалтыг нийт 46 удаа сургалт зохион байгуулж 6000 сурагч хамрагдсан 3. Төсөлд хамрагдсан сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдад “Шинэ үеийн хүүхдүүдийн сэтгэл зүйн онцлог ба мэргэжил сонголт” сэдвээр 1-.2 давтамжаар 26 удаагийн сургалт зохион байгуулж шинэ мянганы хүүхдүүдийн сэтгэл зүйн онцлог, хүүхдээ хэрхэн ойлгох, хүүхдийнхээ ирээдүйн мэргэжилд хэрхэн хандах, мэргэжлээ | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сонгоход нь хүүхдэдээ хэрхэн зөвлөн туслах, үнэлгээний ач холбогдол, төслийн талаар танилцуулга, мэдээллийг олгосон сургалт зохион байгуулсан 3. “Мэргэжил сонголтын олон улсын аргачлал, ирээдүйн чиг хандлага ", "Vocation” үнэлгээний үр дүнд зөвлөгөө өгөх арга зүй" , "“Зөвлөхийн ур чадвар” сэдвээр 20 сургуулийн 600 багшид сургалт зохион байгуулж, мэргэжил сонголтод хэрхэн зөвлөн туслах аргачлалд сургасан 4. Төслийн хүрээнд 20 сургуулийн 6236 хүүхдэд “Ажил мэргэжлийн сонирхол карьерын чиг баримжааг тодорхойлох үнэлгээ”-нд хамрагдуулж тайланг сургуулийн төсөл хариуцсан ажилтанд илгээсэн. Тус үнэлгээгээр сурагчид ажил мэргэжлийн сонирхол, давуу тал, суралцах хэв маяг 6 салбарын 150 гаруй ажил мэргэжлийн нийцлээ тодорхойлуулж, өөрийн сонирхлоо таньж мэдэн, ямар салбар мэргэжилд нийцэлтэйгээ мэдэж авсан.<br>Хавсралт: 8 файл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |
| 9 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 1. ТАХ-ийн 2024 оны жилийн эцсийн Гүйцэтгэл үр дүнг хугацаанд нь тайлагнаж 99,53%-тай үнэлэгдсэн 2. БЕГ болон СХГ-ын 2024 оны жилийн эцсийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийг цаг хугацаанд нь гарган хүргүүлсэн 3. ТАХ-ийн 2025 гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна 4. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын хэрэгжилт, тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажиллаж байна | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% |
| 10 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | | | | Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд: 1. ТАХ-ийн 2024 оны архивын нэгжийг бүрдүүлэн хүлээлгэн өгсөн 2. Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж, 2024 оны ХАСХОМ-оо хугацаанд нь үнэн зөв гаргасан | сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |
| 11 | Ерөнхий газрын даргын шуурхай хурал, даргын зөвлөлийн хурал, Суралцагчийн хөгжлийн газрын шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 1. “Удирдах ажилтны манлайлал” сургалтыг 2025 оны 1 сард зохион байгуулж, Дорноговь аймгийн СӨБ-ын 37, ЕБС-ын 97 удирдах ажилтан, багш нар хамруулав. 2. "Боловсролын салбарын бодлогын хэрэгжилтэд удирдах ажилтны манлайлал" сургалтыг 2025 оны 3 сард зохион байгуулж, Төв | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аймгийн 35 захирал, 39 эрхлэгч, дарга, 3 мэргэжилтэн, нийт 79 хүн хамруулсан. 3. "Сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгаалал, аюулгүй байдлыг хангах, хоол үйлдвэрлэл үйлчилгээг сайжруулахад арга зүйн дэмжлэг үзүүлэх" сургалт зохион байгуулж, Төв аймгийн ЕБС-ын 33 нийгмийн ажилтан, 6 сэтгэл зүйч, 13 эмч, цэцэрлэгийн 22 арга зүйч, 13 эмч, 16 багш, нийт 99 хүн хамруулсан. 4. “Суралцагчийн хөгжил, төлөвшил, хамгаалал, аюулгүй байдлыг хангахад арга зүйн дэмжлэг үзүүлэх” сургалт зохион байгуулахад хамтран ажиллаж, “Сургуульд суурилсан АМЧБО үйл ажиллагаа” сэдвээр Завхан аймгийн 43 нийгмийн ажилтанд мэдээлэл хийсэн 5. МҮОНТ, Өлзий телевиз, ETV, C1 телевиз бусад мэдээллийн сувгуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох чиглэлээр мэдээлэл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хийсэн. 6. Нийслэлийн 116 дугаар сургуулийн 2024-2025оны хичээлийн жилд зохион байгуулсан "Сургуульд суурилсан хичээлийн судалгаа"-ны үр дүнгийн мэдээллийг 5 цувралаар бэлтгэж, БЕГ-ын пэйжээр түгээн дэлгэрүүлсэн.<br>Хавсралт: 3 файл | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субъект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссаан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Ажлын чиг үүргийн дагуу уулзалт, зөвлөгөөн, форум, сургалтад хамрагдах; | Цаг үеийн сургалт зөвлөгөөн, уулзалтад хамрагдах | 100 | 100 | 1. НДЕГ-аас зохион байгуулсан Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийг ажил олгогч, даатгуулагчдад таниулах, мэдээллээр хангах сургалт 2. ЗУГ-аас зохион байгуулсан 2025 оны төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлууд болон 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн дүгнэлт мэдээллийн сургалтад хамрагдсан 3. Өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Сургагч багшийн сургалтад хамрагдав. 4. НҮБ-ын ХАС-ийн "Ээлтэй сургууль" төслийн сургалтад хамрагдан үндэсний сургагч багшаар ажиллаж байна 5. Бусад цаг үеийн уулзалт зөвлөгөөнд бүрэн хамрагдсан | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Ажил мэргэжлийн чиг баримжаа, оюутны хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн, Цэдэндамбаа Намжилмаа
/................................................./ Огноо: .........................